



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 05 дугаар сарын 01

№ 12/65 УАГ-НАГ/2017/01-НА

угаанбаатар хэт

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт”-д хийсэн нийцлийн аудитаар 30,000,000.00 /Гучин сая/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Дундговь аймгийн Гурвансайхан сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 29 өдрийн 03 дугаар “Сумын 2016 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор “Нэмэгдүүлсэн орлого” болох хандив тусламжийн орлогыг 50,000,000.00 /Тавин сая/ төгрөгөөр баталсан хэдий ч “ЖИ ПИ ЭФ” ХХК-аас 2016 онд тус суманд өгсөн хандивыг холбогдох хууль тогтоомжийн дагуу “Орон нутгийн хөгжлийн сан”-д орлогоор төвлөрүүлээгүй, тус сумын Ахмадын хорооны дансаар дамжуулан, иргэн Насанжаргалын Дуламын Хаан банкин дахь /5454115328/ тоот дансруу шилжүүлэн зарцуулж, орон нутгийн төсөвт 30,000,000.00 /Гучин сая/ төгрөгийн хохирол учруулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т /Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:/, 60.2.5-д /тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж./, 4.1.14./“орлого” гэж тухайн этгээдийн дотоод гүйлгээнээс бусад гаднаас хүлээн авах бүх төрлийн гүйлгээг;/, 5.1.2-т /төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;/, 6.1-д /Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй./, 6.3.4-т /төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх./ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын

явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөгцөл байдал;/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламжын орлогыг ОНХС-д 100 хувь төвлөрүүлж, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зарцуулж байх;
2. Дээрхи зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй ажиллах.

Албан шаардлагын биелэлтийг 2017 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Гурвансайхан сумын Засаг дарга /Э.Загдсүрэн/, Засаг даргын орлогч /С.Өлзийбуян/, санхүүгийн албаны дарга /Ү.Алимаа/, нягтлан бодогч /Д.Баярцэнгэл/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН ¹ :		ЗӨВШӨӨРСӨН:	
АУДИТОР	Х.ГАРАМ	ЗАСАГ ДАРГА	Э.ЗАГДСҮРЭН
		ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ	С.ӨЛЗИЙБУЯН
		САНХҮҮГИЙН АЛБАНЫ	
		ДАРГА	Ү.АЛИМАА
		НЯГТЛАН БОДОГЧ	Д.БАЯРЦЭНГЭЛ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.